



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/364

Булган сум

Шүлхий өвчнөөс сэргийлэх нэгдсэн
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дугаар “Шүлхий өвчнөөс сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын нэгдсэн дархлаажуулалтын төлөвлөгөө, хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулж, шаардагдах вакцин, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Сум орон нутагтаа дархлаажуулалтын арга хэмжээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, хүн хүч, машин техник, шатахуун, шаардагдах хөрөнгөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 21-ны/ний өдрийн А.К.364 дугаар
захирамжийн хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Оны эхний үхэр	Хорогдол	Үхэр	Гахай
1	2	3	4	5	6
1	Баян-Агт	6,878	1,791	5,087	32
2	Баяннуур	11,680	3,528	8,152	
3	Бугат	22,223	606	21,617	50
4	Булган	8,927	173	8,754	20
5	Бүрэгхангай	27,798	2,234	25,564	17
6	Гурванбулаг	14,371	3,401	10,970	
7	Дашинчилэн	16,269	1,470	14,799	6
8	Могод	20,175	1,653	18,522	
9	Орхон	31,350	1,569	29,781	193
10	Рашаант	9,695	1,113	8,582	65
11	Сайхан	20,351	3,084	17,267	5
12	Сэлэнгэ	28,664	1,129	27,535	500
13	Тэшиг	28,633	63	28,570	144
14	Хангал	23,904	715	23,189	300
15	Хишиг-Өндөр	14,172	1,270	12,902	
16	Хутаг-Өндөр	42,106	1,108	40,998	573
	Дүн	347,196	24,907	322,289	1905